

ИННОВАЦЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ИННОВАЦ, ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ЛУВСАНДОРЖ ОВОГТОЙ НАРМАНДАХЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Нийгэм, эдийн засгийг инновац шингэсэн технологиор хөгжүүлэх, инновац шингэсэн технологиудыг нутагшуулах, турших, инновацын бодлогын хэрэгжилтийг зохицуулах							
1.	Арга хэмжээ 1.1. Инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг шинэчлэн боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	Хүргүүлсэн төслийн тоо	-	1	Тайлант хугацаа болоогүй.		
2.	Арга хэмжээ 1.2. Инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын болон тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	Хүргүүлсэн төслийн тоо	-	1	“Инновацын төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх, инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ыг шинэчлэн боловсруулж, 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 01/832 тоот, 04 дүгээр сарын 11-ний өдрийн 01/832 тоот албан бичгээр Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга нараас санал авахаар хүргүүлсэн. Нийт 20 байгууллагаас санал ирснийг нэгтгэн, саналыг тусган Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр 2025 оны 05 дүгээр сарын 01-ны өдрийн 01/1029 тоот албан бичгийг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Тус тогтоолын төсөл нь Засгийн газрын 2025 оны 05 дүгээр сарын 07-ны өдрийн 224 дугаар тогтоолоор батлагдсан.	01.10 06.10	100
3.	Арга хэмжээ 1.3. Шилдэг инновацын төсөл шалгаруулах хөтөлбөрийг орон даяар зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	-	1	“Инновацын төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх журам”-ын 3.5-д заасан “Инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах, мэргэжлийн шинжээчдийн ажиллах журам”-ын төслийг боловсруулан хуулийн хэлтсээс санал авахаар хүргүүлсэн. Журмын төсөл хянуулах шатандаа явж байна. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 224 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1-т заасны дагуу	01.10 06.10	70

					инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох сонгон шалгаруулалт зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг, удирдамжийг боловсруулан Сайдын газрын 2025 оны 06 дугаар сарын 06 өдрийн ... дугаар тушаалаар батлуулж сонгон шалгаруулалтын ажлыг эхлүүлсэн.		
4.	Арга хэмжээ 1.4. Салбарын судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээг хангах, тэдний чанарыг сайжруулах зорилгоор цалинтай PhD доктор хөтөлбөрийг боловсруулна.	Хөтөлбөрийн тоо	-	1	Тайлант хугацаа болоогүй.		
5.	Арга хэмжээ 1.5. "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны хөгжил-2025" бүсийн зөвлөгөөн зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	-	1	Зүүн бүсийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, бүс нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх зорилгоор "Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын зүүн бүсийн чуулга уулзалт"-ыг Хэнтий аймгийн төв Чингис хотод 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Чуулганаар зүүн бүсэд тулгарч буй нийгмийн асуудлыг дижитал технологи нэвтрүүлэн шийдвэрлэх, орон нутгийн бизнест дижитал шийдлийг нэвтрүүлэх, орон нутгийн гарааны бизнесийг хөгжүүлэх зэрэг асуудлаар форум хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн чуулганы үеэр "Мэдээллийн технологийн төрөлжсөн төв байгуулах", "Зүүн бүсийн логистикийн төв байгуулах" санамж бичгүүд зурагдаж, зүүн бүсийн 45 суманд төрийн үйлчилгээний КИОСК машиныг гардуулах, Хиймэл Оюуны илч "1000 AI Ambassador" хөтөлбөрийн нээлт зэрэг арга хэмжээг зохион байгуулсан. Тус чуулга уулзалтыг зохион байгуулах бэлтгэл ажилтай холбоотойгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: a. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын нэгдсэн чуулга уулзалтыг Хэнтий аймгийн төв Чингис хотод зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/44 дугаар тушаалаар байгуулсан. b. Ажлын хэсгийн хурлын нийт 3 удаа зарлан хуралдуулсан ба тус чуулганыг 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Хэнтий аймгийн төв Чингис хотод зохион байгуулахаар төлөвлөн ажлын хэсгийн гишүүдэд ажил үүргийг хуваарилан хэрэгжүүлсэн. c. Чуулга уулзалтын бэлтгэл ажил, оролцогчдын бүртгэл, зохион байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн. d. Хэнтий аймгийн төв Чингис хотод 2025 оны 03 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд томилогдон ажилласан.	01.10 04.01	100

6.	Арга хэмжээ 1.6. "ICT экспо 2025" арга хэмжээг зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	-	1	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах, төрийн болон салбарын хувийн хэвшлийн байгууллагуудын дунд салбар хэлэлцүүлэг, "ICT EXPO-2025" үзэсгэлэнг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Сайдын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/38 дугаар тушаалаар байгуулсан. "ICT EXPO-2025" арга хэмжээг 2025 оны 09 дүгээр сарын дундуур зохион байгуулахаар төлөвлөсөн. Тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн "ICT ЭКСПО 2025" ЦХИХХЯ/20250103113 дугаартай арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/113 дугаар тушаалаар байгуулсан. Тус тендер шалгаруулалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулан 06 дугаар сарын 03-ны өдөр тендерийг нээгээд байна.	01.10 06.10	70
Зорилт 2. Хиймэл оюун, их өгөгдөл зэрэг дэвшилтэт технологид тулгуурлан нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгах, хиймэл оюун ухаанд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэхэд салбар хоорондын уялдааг хангах							
7.	Арга хэмжээ 2.1. Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	-	1	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн төслийг хэлэлцүүлэх анхдугаар чуулганыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Уг чуулганд гадаадын болон дотоодын илтгэгч, панелист, төр, хувийн хэвшлийн 1000 орчим төлөөлөл оролцож, их өгөгдөл, хиймэл оюуны чиглэлийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. Уг чуулганыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн: 1. Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/172 дугаар тушаалаар байгуулагдсан Хиймэл оюун ухааны стратеги төлөвлөгөө боловсруулах, олон улсын дээд хэмжээний арга хэмжээ зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг 1 дүгээр сарын 22, 27, 02 дугаар сарын 05, 10, 11-ний өдрүүдэд зохион байгуулсан. 2. Арга хэмжээ зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулсан. 3. Арга хэмжээний нэгдсэн хөтөлбөрийн төсөл боловсруулан ажлын хэсэгт танилцуулсан.	01.10 02.16	100

					4. Төсвийн тооцоо хийж, зардалтай холбоотой тушаал, гэрээний төслийг бэлтгэсэн. 5. Хэлэлцүүлэгт оролцогч модератор, панелистуудыг сонгох, оролцоог баталгаажуулах ажил хийгдэж байна. 6. Тус яамны төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/172 дугаар тушаалын хавсралтаар баталсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/28 дугаар тушаалыг гаргасан. 7. Чуулганы модератор, панелистуудтай уулзах урьдчилсан уулзалтыг 02 дугаар сарын 11-ний өдөр UN house дээр зохион байгуулав. 8. Чуулганы үеэр яамны зүгээс танилцуулах стратеги төлөвлөгөөний танилцуулгыг арга хэмжээний хаалтын үгийн хамт бэлтгэсэн.		
8.	Арга хэмжээ 2.2. Хиймэл оюуны засаглалыг бий болгох судалгаа боловсруулах, төр болон хувийн хэвшилд шат дараалалтай нэвтрүүлэхэд замын зураглал боловсруулна.	Боловсруулсан баримт бичгийн тоо	-	1	Тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн “Хиймэл оюун ухааны засаглалыг бий болгох судалгаа боловсруулах, төр болон хувийн хэвшилд шат дараалалтай нэвтрүүлэхэд замын зураглал боловсруулах” ЦХИХХЯ/20250203067 дугаартай үйлчилгээний тендер шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/83 дугаар тушаалаар байгуулсан. Тус үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг зохион байгуулж, хамгийн сайн тендер ирүүлсэн “Дижитал воркс” ХХК-ыг шалгаруулан мэдэгдэл хүргүүлсэн. Үүний дагуу “Дижитал воркс” ХХК-тай тус ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулах, эрх олгох, зардал гаргах тухай Төрийн нарийн бичгийн даргын А/49 тушаал гаргуулан гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч компани эхлэлийн болон эцсийн тайлангаа ирүүлсэн.	01.10 06.10	100
Зорилт 3. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах							
9.	Арга хэмжээ 3.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд нь бүрэн архивлана.	Архивт хүлээлгэн өгсөн баримт бичгийн тоо	-	Тухай бүр	Архив албан хэрэг хөтлөлтийн 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад хүлээлгэн өгөх материал байхгүй ба 2025 онд Инновацийн бодлого зохицуулалтын газрын үйл ажиллагаатай холбоотой болон үнэлгээний хорооны нарийн бичгээр ажилласан баримтуудаа архивлахаар архивын нэгж үүсгэн ажиллаж байна. Тус баримтуудыг 2026 оны 1 дүгээр улиралд архивд хүлээлгэн өгнө.	01.10 06.10	100

10.	Арга хэмжээ 3.2. Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө оруулалтын мэдүүлэг гаргах	ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргасан байна	-	Тухай бүр	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг зааврын дагуу гарган 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдөр баталгаажуулсан. Инновацын бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтнээр томилогдсонтой холбогдуулан 2025 оны 04 дугаар сарын 05-ны өдөр Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг зааврын дагуу гарган баталгаажуулсан. Мөн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг холбогдуулан 2025 оны 02 дугаар сарын 19, 05 дугаар сарын 15-ны өдрөөр гарган баталгаажуулсан.	01.10 06.10	100
11.	Арга хэмжээ 3.3. Төрийн жинхэнэ албан хаагчийн төлөвлөгөө боловсруулж, нэгжийн удирдлагаар баталгаажуулах, тайлагнах	Батлагдсан загварын дагуу тайлагна.	-	Тухай бүр	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж газрын даргаар батлуулсан. Өөрийн болон нэгжийн гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь гарган тайлагнасан.	01.10 06.10	100
12.	Арга хэмжээ 3.4. Удирдлагаас хуваарилсан албан бичгийг шийдвэрлэх, хариуцсан ажлын чиглэлээр албан бичиг боловсруулж, стандартын дагуу гаргах	Ирсэн албан бичгийг хугацаандаа шийдвэрлэсэн байна	-	Тухай бүр	Тайланг хугацаанд нийт 35 албан бичиг хугацаанд нь шийдвэрлэж, 23 бичиг боловсруулан илгээсэн. Хуучнаар Боловсрол шинжлэх ухааны яамнаас хэрэгжүүлсэн "Мон Икс 2024" инновацын хөтөлбөрийн хүрээнд иргэн С.Золбаяр нарын 9 иргэнээс ирсэн грантын санхүүжилтийг олгох талаар өргөдөлд хариу тайлбар боловсруулан 2024 оны 04 сарын 16-ны өдрийн 02/853 дугаар албан бичгийг иргэн С.Золбаяр нарын 9 иргэнд хүргүүлэв. Мөн тус гомдолтой холбоотой тайлбарыг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2024 оны 05 сарын 01-ний өдрийн 02/1032 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	01.10 06.10	100

Гурав. Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд санал боловсруулж оруулах	Оруулсан саналын тоо	-	3	Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд тус газраас хэрэгжүүлэхээр төлөвлөж буй дараах арга хэмжээ, төслийн танилцуулгыг холбогдох мэдээллийн хамт бэлтгэн Стратеги, бодлого, төлөвлөлтийн газарт өгсөн. а. Хиймэл оюуны үндэсний хэмжээний тогтолцоог бүрдүүлж, GPU кластер бүхий төв байгуулах; б. Мэдээллийн технологийн төрөлжсөн төв байгуулах; с. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн туршилтын бүс байгуулах.	01.10 06.10	100

2.	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй 2022 онд байгуулсан Харилцан ойлголцлын Санамж бичгийн хүрээнд хамтран ажиллах	Баталсан төлөвлөгөөний й тоо	-	1	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй 2022 онд байгуулсан Харилцан ойлголцлын Санамж бичгийн хүрээнд инновац үйлдвэрлэлийн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор хамтарсан төсөл эхлүүлэх төлөвлөгөөг байгуулахаар төлөвлөгөөний төслийг айлын талтай эцэслэсэн, тус төлөвлөгөөг хянуулахаар Гадаад харилцааны яам руу 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/179 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Үүний дагуу төсөл эхлүүлэх төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 03-нд байгуулсан. Тус төлөвлөгөөнд заасан ажлуудыг санхүүжүүлэх зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй Г/02 "Санхүүжилтийн гэрээ"-г 2025 оны 02 дугаар сарын 12-нд байгуулсан. Гадаад харилцааны яаманд гэрээг бүртгүүлэхээр гэрээний эх хувийг Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэст хүлээлгэн өгсөн.	01.10 02.20	100
3.	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Дархан- Уул аймагт "Цахим үйлчилгээний хөдөлгөөнт цэг, Цахим ур чадварын төвийг байгуулах" туршилтын төсөл хэрэгжүүлэх	Хэрэгжүүлсэн төслийн тоо	-	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, олон нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх (DEMOSC) төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сантай хамтран ажиллах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг Дархан-Уул аймагт хэрэгжүүлж байгаа төслийн ажлын явц, санхүүжилтийн хуваарийн талаар мэдээлэл солилцох уулзалтуудыг 2025 оны 01, 02 дугаар саруудад зохион байгуулсан ба уулзалтаар Цахим ур чадварын төвийн бэлтгэл ажил, хөдөлгөөнд станцын машины техникийн үзүүлэлтийн талаар санал солилцон тодорхой саналууд дээр харилцан санал солилцон шийдвэрлэж ажилласан. Энэхүү Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран "Strengthening Digital E-mongolia Services and Communities (DEMOSC)" төслийн хүрээнд Дархан-Уул аймагт хэрэгжүүлж байгаа "Цахим үйлчилгээний хөдөлгөөнт цэг, Цахим ур чадварын төвийг байгуулах" ажлын явцын мэдээллийг 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан. Төсөл амжилттай хэрэгжиж 2025 оны 06 дугаар сард нээлтээ хийхээр ажиллаж байна.	01.10 06.10	100
4.	Төрийн нарийн бичгийн 2025 оны А/01 дугаар тушаалаар батлагдсан худалдан авах	Зохион байгуулсан худалдан авах	-	3	Төрийн нарийн бичгийн 2025 оны А/01 дугаар тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тус газартай холбоотой нийт 33 ажил төлөвлөгдсөнөөс дараах ажлын даалгавруудыг боловсруулан батлуулсан.	01.10 06.10	100

	ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх	ажиллагааны тоо			○ Хиймэл оюун ухааныг засаглалыг бий болгох судалгаа боловсруулах, төр болон хувийн хэвшилд шат дараалалтай нэвтрүүлэхэд замын зураглал боловсруулах; ○ "ICT экспо 2025" арга хэмжээг зохион байгуулах; ○ Салбарын судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээг хангах, тэдний чанарыг сайжруулах зорилгоор цалинтай PhD доктор хөтөлбөрийг боловсруулах Тус яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан "Хиймэл оюун ухааны засаглалыг бий болгох судалгаа боловсруулах, төр болон хувийн хэвшилд шат дараалалтай нэвтрүүлэхэд замын зураглал боловсруулах" ЦХИХХЯ/20250203067 дугаартай үйлчилгээний тендер шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/83 дугаар тушаалаар байгуулсан. Тус үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг зохион байгуулж, хамгийн сайн тендер ирүүлсэн "Дижитал воркс" ХХК-тай гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч компани эхлэлийн болон эцсийн тайлангаа ирүүлсэн. Мөн "Өгөгдлийн стратеги боловсруулах", "ICT экспо 2025 арга хэмжээг зохион байгуулах" үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/113 дугаар тушаалаар байгуулсан. Тус үнэлгээний хороо "Өгөгдлийн стратеги боловсруулах", "ICT экспо 2025 арга хэмжээг зохион байгуулах" ажлуудын тендер шалгаруулалтыг зохион байгуулж, "Өгөгдлийн стратеги боловсруулах" тендер шалгаруулалтад хамгийн сайн тендер ирүүлсэн "Систем арт венчурс" ХХК-тай гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн. "ICT экспо 2025 арга хэмжээг зохион байгуулах" ажлын тендерийг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр нээсэн. Тендер үнэлэх ажил хийгдэж байна. Тус ажлыг гүйцэтгүүлэхээр Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/190 дугаар тушаалаар "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн платформыг хөгжүүлэх" ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог байгуулан ажиллаж байна.		
5.	Ухаалаг засаг-2 төслийн хүрээнд "Цахим шилжилтийн талаар хууль, тогтоомжийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах" зөвлөх үйлчилгээний гэрээт	Хянасан тайлангийн тоо	-	1	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн А/72 дугаар тушаалаар Ухаалаг засаг-2 төслийн хүрээнд "Цахим шилжилтийн талаар хууль, тогтоомжийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах" зөвлөх үйлчилгээний гэрээт ажлын явцын болон гүйцэтгэлийн тайланг хянан	03.24 06.10	100

	ажлын явцын болон гүйцэтгэлийн тайланг хянан баталгаажуулах				баталгаажуулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хурлыг 3 удаа зохион байгуулж гүйцэтгэгч "Эм Эн Маркетинг консалтинг" ХХК-аас ирүүлсэн эхлэлийн тайлан болон "Олон нийттэй харилцах стратеги"-ийн төслийг хэлэлцэн санал солилцсон. Ирүүлсэн 1, 2 дугаар тайланг хүлээн авч баталгаажуулах ажил хийгдэж байна.		
6.	"Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр"-ийн биелэлт хүргүүлэх	Хүргүүлсэн албан бичгийн тоо	-	1	"Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр"-ийн биелэлтийг 2024 оны байдлаар гарган Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 03/322 дугаартай албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэв.	01.10 02.07	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Хариуцсан ажлын чиглэлээр байгууллагаас болон бусад газраас зохион байгуулсан сургалт, семинарт оролцох	Хамрагдсан сургалтын тоо	-	1	Сайдын зөвлөх Б.Цэсүрэнгийн "Мэдээллийн технологи, хиймэл оюун ухааны хөгжлийн чиг хандлага" сэдвээр 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан сургалтад хамрагдсан. Эдийн засаг, хөгжлийн яам, НҮБ-ын худалдаа, хөгжлийн байгууллага (UNCTAD)-ын хамтран 04 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд зохион байгуулсан Шинжлэх ухаан, технологи, инновацын паркийн бодлого, практикийн талаарх үндэсний сургалт, семинарт хамрагдан сертификат авсан. БНХАУ-ын Бээжин хотноо 05 дугаар сарын 11-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Хиймэл оюуны чадавхыг бэхжүүлэх семинар"-т оролцон сертификат авсан. Гадаад томилолтын тайланг хугацаанд нь гарган Гадаад хамтын ажиллагааны хэлтэст хүргүүлсэн.	01.10 06.10	100
2.	Арга хэмжээ 2. Худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдаж АЗ гэрчилгээ авах	Гэрчилгээний хүчинтэй хугацаа	Хугацаа дууссан	3 жилийн хүчинтэй гэрчилгээ	Худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдаж 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр шалгалт өгөн 2025/1378 дугаар бүхий АЗ гэрчилгээ авсан.	01.10 06.10	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

Инновац, технологи дамжуулалт
хариуцсан ахлах мэргэжилтэн
(Албан тушаал)

Л.Нармандах Л.Нармандах
(Нэр, гарын үсэг)

2025.06.06
(Огноо)